

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

Өдөр +18
Шөнө +4

УЛС ТӨР

Ж.МӨНХБАТ: ЭРГЭН ТӨЛӨЛТИЙГ
НЭМЭГДҮҮЛСЭН БАЙВАЛ БИД
ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХЭД БЭЛЭН

II нүүрт

Дугаарын **60** мөр

АМЖИЛТЫН ЭЗЭН

“Халаасны өрөө”-
гөөр хөлжигсдөд
хяналт тавиач

Н.БАТЗАЯА

“Халаас”-ны өрөө гэх энэхүү нэршил жил бүрийн намар хот суурин газар бараадан их, дээд сургуульд дээд боловсрол эзэмших гэсэн оюутан залуусын эрэлт, хэрэгцээнээс үүдэлтэй гэж хэлж болно. Хөдөө орон нутгаас ирсэн зарим оюутнууд хотод ах дүү, хамаатан садангүй аль эсвэл сургуулийнхаа дотуур байранд орж чадаагүйн улмаас гадаа хонох нь шахуу явсан цаг саяхан. Тиймээс ч сүйхээтэй нэг нь хоёр давхар хүн хоноход тохиромжтой олон жижиг өрөөтэй байшин бариад түүнийгээ оюутан залууст хөлслөх болов. Зарим нэг нь хажуу өрөөгөө мөн л оюутан залууст хөлслүүлдэг жишиг аль хэдийнэ тогтсон.

Үргэлжлэл нь III нүүрт



Т.Орхон

МОНГОЛЫН ЧӨЛӨӨТИЙН ТҮҮХЭН ДЭХ ТАВ ДАХЬ ДЭЛХИЙН АВАРГА БОЛЛОО

Н.ЛУНЦАГ

“Парис-2017” ДАШТ-ий чөлөөт бөхийн эмэгтэйчүүдийн эхний өдөр Азийн АШТ-ий мөнгө, залуучуудын ДАШТ-ий хүрэл медальт, Иван Ярыгиний нэрэмжит “Алтан

Гранпри”-гийн хошой аварга, Үндэсний шигшээ баг, “Алдар” спорт хороо, “Аваргууд” академийн тамирчин ОУХМ Пүрэвдоржийн Орхон Монголын чөлөөт бөхийн тамирчдаас ДАШТ-ээс долоо дахь алтан медалийг авчирч, эх орон, элэг

нэгтгүүдээ баярлууллаа. Тэрбээр Парисын дэвжээнд эхлээд 2012 оны ДАШТ-ий тавдугаар байрын шагналт Энэтхэгийн Шилпи Шераныг оноогоор цэвэр ялсан.

Үргэлжлэл нь V нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ

Иргэдэд газраа өмчлөхөд дэмжлэг үзүүлнэ

Нийслэлийн газрын албанаас иргэдэд оршин суугаа газраа өмчлөхөд дэмжлэг үзүүлэх зорилгоор гурван сарын аяныг зохион байгуулахаар болжээ. Тодруулбал, ирэх сарын 4-нөөс эхлэн гурван сарын хугацаанд хэрэгжүүлэх гэнэ. Аяны хүрээнд нийслэлийн төвийн зургаан дүүргийн гэр хорооллын суурьшлын I, II дугаар бүсэд хамаарах 43 хорооны 3442 нэгж талбарт иргэний, ахуйн зориулалтаар газар эзэмшиж буй иргэдэд газраа өмчлөхөд нь дэмжлэг үзүүлэх аж. Өөрөөр хэлбэл, судалгаанд хамрагдсан 3442 нэгж талбарын эзэмшигч иргэдэд хороогоор дамжуулан тараах материал, зөвлөмж өгч, Газрын албаны мэргэжилтэн тухайн айл бүрт очиж, иргэдтэй уулзан газар өмчлөлийн материалыг бүрдүүлэн авах гэнэ. Нийслэлийн Газрын албанаас өмчлөгдөх боломжтой гэж үзэж буй 79985 нэгж талбар байна гэсэн судалгааг гаргасан бөгөөд 3442 нэгж талбарыг аяны хүрээнд өмчлүүлэхээр төлөвлөжээ. Цаашид үлдсэн 76543 нэгж талбарыг өмчлөлд хамруулах ажлыг дүүргийн Газрын албатай хамтран 2018 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

expo
NARAN VIII/18-IX/3
ҮНЭ ХАЙЛЛАА

SEIKO, Hard Rock CAFE, Del Monte, DELSEY PARIS, ZARA HOME, CINO SHOP, merci, INSANE ENERGY, BOTTEGA, THAI ELEPHANT, New York Liberty, ESPRIT, swatch, adidas, adidas, FOX, granini, celio, Luminarc, YVES ROCHER FRANCE, SWAROVSKI, Enchanteur, Toffifee, KAMILIANT, Timberland, Pfaner, ZARA, THANN, VICTORINOX, TVLIP, Creme 21

BIG SALE 50% хүртэл

1. NARAN PLACE | 13-Р ХОРООЛОЛ ДУНД ЗАМ
2. NARAN MALL | ХҮҮХДИЙН 100
3. NARAN PLAZA | ЭНХТАЙВНЫ ГҮҮР
4. MONGOL EXPO | 13-Р ХОРООЛОЛ 3-Н ӨНДӨР

VIII/18-IX/3 дуустал
7015-6918

ХААН банк	Хуудалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2440.00	2447.00	ФУНТ	3070.00
ЕВРО	2840.00	28904.00	РУБЛЬ	40.30
ИЕН	22.10	22.55	ЮАНЬ	364.00
			Авах	Зарах
			АМ.ДОЛЛАР	2430.00
			ЕВРО	2851.00
			ИЕН	22.02
			ФУНТ	3079.00
			РУБЛЬ	40.48
			ЮАНЬ	364.00

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Эхний ээлжинд
дотоодын
үйлдвэрлэгчдийн
улаанбуудайг
худалдан авна

Засгийн газрын ээлжит хуралдаанаар ургац хуралтын асуудлыг авч хэлэлцжээ.

Ургацын урьдчилсан балансаар нийтдээ 259.2 мянган тонн буудай үтрэм дээр буух төлөвтэй байгаа ажээ. Үүнээс ирэх оны тариалалтад зориулан аж ахуйн нэгж, иргэд 30 мянган тонн буудайн үр нөөцлөх бөгөөд тэжээлд 20.7 мянган тонн, спиртийн үйлдвэрт 12.9 мянган тонныг зарцуулахаар гэнэ. Тиймээс санхүүжилтийн эх үүсвэрийг нь шийдвэрлүүлж, дотоодын ургацаас Тариалан эрхлэгчдийг дэмжих санд 30 мянган тонн үрийн буудай худалдан авч нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулахаар болжээ. Мөн 2018 онд тариалалтад шаардагдах 60 мянган тонн үрийг дотоодоосоо бүрдүүлэхээр тооцоход гурил үйлдвэрлэлд 165.5 мянган буудай нийлүүлэх юм байна. Манай улсын жилийн хэрэгцээт гурилыг дотооддоо үйлдвэрлэхэд 320 мянган тонн улаанбуудай шаардлагатай бөгөөд 2017-2018 оны хэрэгцээнээс 154.5 мянган тонн хүнсний улаанбуудай дутагдах төлөвтэй байгаа аж. Хурлын үеэр эхний ээлжинд дотоодын үйлдвэрлэгчдийн улаанбуудайг худалдан авч, дараагаар нь импортын улаанбуудайн асуудлыг ярина гэдгийг Ерөнхий сайд үүрэг болголоо.

Н.БАТЗАЯА

УИХ дахь МАН-ын 30 гишүүн Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатыг огцруулах тухай албан бичигт гарын үсэг зурж, энэ сарын 23-нд АН-ын дэд дарга Я.Санжмятавт гардуулан өгсөн билээ. Тус албан бичигт концессийн гэрээний асуудлыг дурьдсан байна. Тэгвэл өчигдөр ЗГХЭГ-ын сайд Ж.Мөнхбат дээрх асуудлаар албан ёсны тайлбар хийлээ. Тэрбээр “Манай Засгийн газар гарснаасаа хойш өмнөх Засгийн газрын байгуулсан концессын гэрээг өөрчилж, үнийн дүнг нь бууруулсан. Үнийн дүнг нь бууруулснаар улсын төсөвт хэмнэлт хийж байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл, эргэн төлөлт дээр хэмнэлт хийсэн гэсэн үг. Өнөөдрийн байдлаар концессуудаас улсын төсөвт нэг ч төгрөг эргэн төлөгдөөгүй байгаа. Өөрөөр хэлбэл, 800 тэрбум төгрөгөөр улсыг хохироосон гэж яриад байгаа шүү дээ. Нэг ч төгрөг улсын төсвөөс эргэн төлөлтөд ороогүй. 2019-2023 онд эргэн төлөгдөнө. Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд хүндрэл дарамт учруулахгүйн тулд гэрээг нь шинэчилсэн. Мөрөн-Тариалан, Завхан-Увс, Өмнөговь аймгийн Цогцэдий гэсэн гурван замаас л гэхэд өмнө байгуулсан гэрээнээс 50 орчим тэрбум төгрөгөөр үнийн дүнг нь буурууллаа. Эндээс улсын төсөвт 50 орчим тэрбум төгрөгийн хэмнэлт хийгдсэн гэж ойлгож болно. Мөн долоон концессын бүгдийг нь шинээр хэлэлцсэн зүйл байхгүй. 5-6 концесс нь хуучин эхэлчихсэн байсан. Шийдвэр нь гараад гэрээ контракт нь хийгдчихсэн байсан зүйл. Тухайн замыг барих УИХ, Засгийн газрынх нь шийдвэр гарчихсан байсан шүү дээ. Харин бид 1-2 концессыг



шинээр оруулсан. Нэгдүгээрт, Дорноговь-Дэлгэрэх чиглэлийн автозамын концесс. Энэ бол үндэсний үйлдвэрлэлээ дэмжсэн ажил. Хувийн хэвшилээс 100 орчим сая ам.доллар гаргаад хоёр том үйлдвэр барьж байна. Энэ бол Засгийн газрын

мөрийн хөтөлбөрт орсон 21:10 хөтөлбөрийн хүрээнд үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх татварын орлогыг бий болгох зорилтын дагуу хийгдсэн концессын гэрээ гэж ойлгож болно. Хоёрдугаарт, Хан-Уул дүүрэгт

...Тийм тохиолдолд бид хариуцлага хүлээхэд бэлэн байна. Би ганцхан жишээ хэлье. Хан-Уул дүүргийн 300 хүүхдийн төрөх эмнэлгийг яагаад ашиглалтад оруулах ёстой вэ. Энэ бол нийгмийн зайлшгүй хэрэгцээ шаардлага байна гэсэн үг. Нийгмийнхээ сайн сайхны төлөө бид уг ажлыг хийх ёстой...

баригдаж буй 300 хүүхдийн төрөх эмнэлгийн концессын гэрээ. Бид бүгд л мэдэж байгаа шүү дээ. Одоогийн нийгэмд төрөх эмнэлэг, нярайн эмнэлэг ямар их хэрэгтэй байгааг. Тиймээс нийгмийнхээ эрэлт, хэрэгцээ шаардлагын

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Соёлын өвийг хамгаалах тухай хоёр журам баталлаа

“Соёлын биет өвийн үзлэг тооллого хийх журам”, “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх” журмыг Засгийн газрын хуралдаанаар баталлаа. Эдгээр журмыг баталснаар шинээр орон тоо нэмэгдэхгүй, улсын төсөвт санхүүгийн ачаалал үүсэхгүй бөгөөд соёлын биет өвийн үзлэг, тооллого хийх, түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх үйл ажиллагаа улам боловсронгуй

болж түүнд оролцогч талуудын эрх, үүрэг тодорхой болох юм. Соёлын биет өвийн үзлэг, тооллого хийх журмын төсөлд үзлэг, тооллого хийхэд бэлтгэх, зохион байгуулах, дүн мэдээлэл тайлагнах, үзлэг тооллогын баримтын бүрдэл, түүнийг хамгаалах үйл ажиллагааг боловсронгуй болгож, үзлэг тооллогын комиссын эрх, үүргийг нарийвчлан тусгажээ. “Түүх, соёлын дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх

журам” хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр гаргах, оруулахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг зохицуулна. Тухайлбал, лиценз хүссэн өргөдөл гаргах, түүнийг хянан шийдвэрлэх, лиценз олгох, хосгүй үнэт дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх, лицензид хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг боловсронгуй болгож, лиценз эзэмшигчийн эрх, үүргийг нарийвчлан тусгажээ.

УИХ-ын гишүүн
Д.Гантулгад
эрүүгийн хэрэг
үүсгэжээ

УИХ-ын хамгийн залуу гишүүн хэмээх тодотголыг зүүдэг Д.Гантулга хүчингийн хэрэгт нэр холбогдож, өнөөдрийг хүртэл хохирогч тал гомдол мэдүүлсээр байгаа билээ. Тэгвэл Улсын Ерөнхий прокурорын газраас түүнд эрүүгийн хэрэг үүсгэхэн байна. Баянзүрх дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтэст гаргасан өргөдлөө буцаагаад байсан иргэн Ч.Наранзаяа УЕПГ-т Д.Гантулга гишүүнийг дахин шалгуулах хүсэлт тавьсан байна. Улмаар Д.Гантулга гишүүнд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан Баянзүрх дүүргийн прокурорын шийдвэрийг хүчингүй болгож, эрүүгийн хэрэг үүсгэн, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахыг Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтэст даалгажээ. Гэхдээ цагдаагаас түүнийг баривчлах, хүчээр мэдүүлэх авах боломжгүй. Тийм болохоор УИХ-ын Ёс зүйн дэд хороонд түүний бүрэн эрхийг түр болон бүр чөлөөлөх асуудлыг хууль хяналтын байгууллагаас тавих биз ээ.

Ишиг эврээ ургахаар эхийгээ
гэдэг биш бил үү

МАН-ын 30 гишүүн Засгийн газрыг огцруулах албан бичигт гарын үсэг зурж, өчигдөр УИХ-ын дэд дарга Я.Санжмятавт гардуулан өгсөн. Тэд энэхүү албан бичгээ намынхаа даргад биш АН-ын төлөөлд өглөө гэх “бор шувуу” өнөөдөр ч энд тэндгүй ниссээр. Тэгвэл Засгийн газраа унагахаар гарын үсэг зурсан гишүүдийг шинжвэл дийлэнх нь шинэковууд байх юм аа. Тодруулбал, Т.Аюурсайхан, Б.Батзориг, О.Батнасан, Б.Баттөмөр, Ж.Ганбаатар, Д.Гантулга, Ц.Гарамжав, Б.Жавхлан, М.Оюунчимэг, Л.Оюун-Эрдэнэ, Ш.Раднаасэд, Г.Солтан, А.Сүхбат, Д.Тогтохсүрэн, Н.Учрал, Д.Цогтбаатар, Л.Элдэв-Очир, Б.Энх-Амгалан, Л.Энхболд нарын шинэковууд МАН-аас нэр дэвшиж, анх удаа УИХ-ын гишүүн хэмээх сэтгэр зүүсэн хэрнээ эргээд тонгорч байгааг нь харвал ишиг эврээ ургахаар эхийгээ мөргөнө гэдэгтэй л адил зүйл болж байна. Харин УИХ-д 2-3 удаа сонгогдсон архагууд чимээгүйхэн байдлыг ажиглаж сууна уу гэлтэй.

Учир нь эл албан бичигт Х.Болорчулуун, Ц.Даваасүрэн, Д.Дамба-Очир, Г.Занданшатар, Д.Сарангэрэл, Я.Содбаатар, Д.Сумьяабазар, Ч.Хүрэлбаатар, Ж.Энхбаяр нарын хуучин гишүүд гарын үсэг зурснаас биш парламентын “акул”-ууд таг чиг сууна. Угтаа бол улс төрийг тэднээс илүү мэдэх “акул”-ууд хүний гараар могой барилж байж ч мэдэх юм. Ямартай ч, МАН-аас сонгогдсон учраа мэдэхгүй улстөрчид энэ удаа засгаар тоглох гээд байх шиг. Асуудал хаашаа эргэхийг цаг хугацаа харуулах биз ээ.

Байгаль хамгаалагчид дрон ашиглана



Нийслэлийн есөн дүүргийн 470 мянган га нутаг дэвсгэрийн байгалийн нөөц байлгийг хамгаалах, байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчил, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, ногоон бүсийн цаг уур, орчны өөрчлөлт, төлөв байдалд тандалт судалгаа хийх, ногоон бүс дэх иргэд, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих үндсэн үүргийг Нийслэлийн Байгаль орчны газрын 33 байгаль хамгаалагчид хэрэгжүүлдэг. Өчигдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас олгож буй хамгаалагчдын ажлын бүтээмжийг дээшлүүлж, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд зориулан мэргэжлийн дрон, байршил тодорхойлон мэдээлэл дамжуулах хяналтын систем, төхөөрөмжүүд, моторт хөрөө, үүргийн гал унтраагуур, түймэрт гэсвэртэй ажлын хувцас зэргийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд гардуулан өглөө. Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын баталсан журмын дагуу байгаль хамгаалагчдын хувцас, таних тэмдгийг шинэчилсэн.

Үүний дагуу Нийслэлийн Байгаль хамгаалагчдын шинэ дүрэмт хувцсыг танилцуулж байна. Нийслэл хотын захиргаа байгаль орчныг орон нутгийн иргэдийн хүч, оролцоотойгоор хамгаалах бодлогыг хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд 90 иргэнд идэвхтэн байгаль хамгаалагчийн эрхийг олгож байна. Мэргэжлийн дронаар 500 метрийн өндрөөс долоон км радиус дахь газар нутгийг хянах боломжтой бөгөөд 72 км цагийн хурдтай нисэж зөрчлийг 4К нягтралтайгаар баримтжуулдаг. Гэмт хэрэгтэй тэмцэхээс гадна зэрлэг амьтдын тооллого судалгаа, түймрийн хяналт зэрэгт ашиглагдана. Байршил тодорхойлогч төхөөрөмж нь байгаль хамгаалагчдын явсан зам, чиглэлийг цаг, минуттай мэдэлэхээс гадна тус хяналтын системтэй мэдээлэл солилцох, мессеж явуулах, ойролцоох байгаль хамгаалагчдаас тусламж хүсэх, байршлаа илгээх функцтэй. Байгаль хамгаалах ажилд технологийн дэвшлийг ашигласнаар байгаль хамгаалагчдын аюулгүй байдлыг хангах, зөрчлийг шуурхай хүлээн авч, таслан зогсоох боломжтой болж байна

MINFO
МОНГОЛЫН МЭДЭЭ
19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн: Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар. 209, 211 тоот

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, Чөлөөт хэвлэл сан-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ҮЗЭЛ БОДОЛ

ХЭН ЮУ ХЭЛЭВ

Дугаарын 60 мөр

“Халаасны өрөө”-гөөр хөлжөгсдөд хяналт тавиач



Э.ТУУЛ

Өнгөрч буй долоо хоногт Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ОХУ-ын ТАСС агентлагт анх удаа ярилцлага өглөө. Түүнчлэн улстөрчид буужааж, Засгийн газрыг унагах албан бичгийг өргөн барьж, У.Хүрэлсүх ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж их л адал явдалтай долоо хоног өнгөрлөө. Ингээд өнгөрч буй долоо хоногт хэн, ямар байр суурь илэрхийлснийг тоймлон хүргэж байна.

Х.Баттулга: Далайд гарцгүй манай орны хувьд хөршүүдтэйгээ нягт хамтран ажиллах нь чухал

/Монгол Улсын Ерөнхийлөгч/

Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга ОХУ-ын мэдээллийн ТАСС агентлагийн сурвалжлагч Алексей Селищевийн тавьсан асуултад хариулж, ярилцлаа. Энэ үеэр Ерөнхийлөгч Х.Баттулга “Ерөнхийлөгчийн сонгууль өнгөрөөд дөнгөж сар гаруйхан хугацаа өнгөрч байна. Улс орныхоо гадаад бодлогын талаар надад бодож төлөвлөсөн олон санаа, төлөвлөсөн ажлууд бий. Монгол Улс газар нутгийн байршлын хувьд Ази тивд байдаг учраас Азийн бүх улс оронтой дипломат харилцаатай явж ирсэн. Гэхдээ бидэнд нэг онцлог бий. Энэ нь манай улс хоёр том гүрэн, тодруулбал, Орос, Хятадын

ирсэн. Ийм байдлаар улс төр, бизнесийн бүлэглэлүүдийн хувийн ашиг орлого нь өссөөр байна. Үр дүнд нь нэг талаас, Монголд ядуурал, ажилгүйдэл нэмэгдэж, нөгөө талаас, улс төрийн бүлэглэлүүд хөрөнгөжиж нөөц баялаг нь өсөх нөхцөл бүрдсэн. Энэ бол миний хамгийн гол сэдвийн нэг юм. Миний хувьд өөр нэг чухал чиглэл бол дэд бүтэц. Энэ салбарыг манай ард түмэн өөрсдөө бүтээж хөгжүүлэх ёстой. Энэ салбар Орос, Хятад гэсэн хоёр хөрштэйгээ дэд бүтцийн салбарт харилцах гол чиглэл байх ёстой. Далайд гарцгүй манай орны хувьд хөршүүдтэйгээ нягт хамтран ажиллах нь чухал юм” хэмээн онцлон тэмдэглэжээ.

С.Мөнхчулуун: Намын дүрэм бол гишүүддээ Үндсэн хууль мэт байх ёстой

/НИТХ-ын МАН-ын бүлгийн дарга/

НИТХ дахь МАН-ын 16 гишүүн Иргэдийн хурлын даргыг огцруулах тухай хүсэлт гаргаж, гарын үсэг цуглуулсан. Улмаар ИТХ-д хүргүүлэхэд байгаа. Энэ талаар НИТХ-ын МАН-ын бүлгийн дарга С.Мөнхчулуун мэдээлэл хийж, байр сууриа илэрхийлсэн юм. Тэрбээр “Өвөлжилтийн бэлтгэл, хичээлийн шинэ жилийн нээлтээс авахуулаад олон ажил хаяанд ирчихлээ. Улс оронд хийх ажил их байхад хажуугаар нь улс төр хийгээд байгаа нь харамсалтай байна. НИТХ дахь МАН-ын бүлэг нийтдээ 34 төлөөлөгчтэй. Түүний 16 нь НИТХ-ын дарга Ц.Сандуйг огцруулахаар гарын үсэг зурсан. Энэ нь олонхи болохгүй гэсэн үг. АН-ын бүлгийн 11 төлөөлөгч нэмэгдээд гарын үсэг зурж байгаа юм билээ. Нийлээд 27 төлөөлөгч болсон. Тэгсэн ч Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны хүрээнд Иргэдийн хурлын хэмжээнд хүрээгүй. Дээрээс нь гарын үсэг зураагүй МАН-ын төлөөлөгчид 60 тэрбумын хэрэгт холбогдоод байгаа хүмүүсийг өмгөөлж хамгаалж байна гэсэн мэдээллийг хэвлэлээр болон социалаар тарааж байна. Тийм юм байхгүй. МАН-ын бүлэг гэдэг бол өөрөө намын дүрэмд байдаг нэг бүтэц. Бид нийслэлийн МАН-ыг төлөөлж энд сууж

байгаа. Нийслэлийн МАН-ын тэргүүлэгчид хуралдаж, ямар нэгэн шийдвэр гаргаагүй байна. Нөгөө талаар өнгөрсөн долоо хоногт МАН-ын Удирдах зөвлөл хуралдсан. Намын Удирдах зөвлөл хуралдаад, өнгөрсөн Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотойгоор ямар нэгэн албан тушаалтанд хариуцлага тооцохгүй гэж шийдвэр гаргасан. Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой хариуцлагын асуудлыг МАН-ын Их хурлаар ярина. Их хурал есдүгээр сард хуралдана. Ердөө л 20 орчим хоногийн дараа хурал болох гэж байхад наана нь улстөржиж, намыг хагалан бутаргаж, төр захиргааны ажлыг цалгардуулах, тогтворгүй байдал үүсгэх хэрэггүй байгаа юм. 27 төлөөлөгч гарын үсэг зурсан, Иргэдийн хурлын даргыг огцруулна гэж АН-ын бүлгээс мэдээлэл хийсэн. Тэглээ гээд Иргэдийн хурлыг даргыг огцруулж болохгүй гэдгийг би хэлэх гэж дахин сануулаад байна. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль бол орон нутгийн байгууллагуудын мөрдөх ёстой Үндсэн хууль л гэсэн үг. Бид энэ хуулийг л барьж ажилладаг. Энэ хуулинд Иргэдийн хурлын даргыг гарын үсэг цуглуулаад огцруулна гэсэн заалт байхгүй. НИТХ-ын гишүүдийн 30 нь буюу гуравны хоёроос дээш төлөөлөгч гарын үсэг зурсан бол ээлжит бус хурлыг хуралдуулна гэсэн заалт бий. Мөн нийт төлөөлөгчдийн гуравны хоёроос дээш гишүүн санал гаргавал хурал тарна гэсэн заалт байгаа. Төлөөлөгч нар гарын үсэг цуглуулаад, Иргэдийн хурлын даргыг огцруулах боломжгүй гэдгийг тэд бүгдээрээ мэднэ. Тэгсэн мөртлөө улс төрийн зорилготой үйлдүүдийг хийж байгаа нь харамсалтай байна. Өнөөдөр бид улс төр хийх гэж энд ажиллаагүй. Нийслэлийн сая гаруй иргэдийн амьдрал ахуйг дээшлүүлэх л гэж ажиллаж байгаа. Аль аль намын бүлэг нь тийм зорилготой ажиллаж байгаа гэж би боддог. Одоо улстөржилтөө зогсоож, өвлийн бэлтгэл, сургууль, цэцэрлэгийн нээлт гээд ажлууддаа анхаарлаа хандуулаар байна. Дээрээс нь би бүлгийн даргын хувьд төлөөлөгчидөө хандаж хэлье. Нэгэнт бид намын дүрэмтэй. Дүрэм бол намын гишүүддээ Үндсэн хууль мэт байх ёстой. Намын нэрээр өрсөлдсөн, сонгогдсон, албан тушаалд томилогдсон. Тийм болохоор намын дүрмийнхээ хүрээнд ажиллаач гэж хэлье. Бага хурал, Их хурал ирэх сард болно. Түүнээс өмнө улстөржөөд яах

юм бэ л гэж хүсмээр байна” хэмээжээ.

Л.Оюун-Эрдэнэ: Тэгвэл М.Энхболд дарга Б.Баатар хоёрын утасны яриаг гаргаж тавь л даа

/УИХ-ын гишүүн/

Шадар сайд У.Хүрэлсүх болон “Херо” энтертайнментын захирал Б.Баатар нарын хоорондоо ярьсан утасны бичлэг алдагдаж, багагүй шуугиан тарьсан билээ. Тэр ярианд нэр нь хамгийн их дурьдагдсан хүн бол УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэнэ. Тэгвэл тэрбээр энэ асуудлаар байр сууриа илэрхийллээ. Л.Оюун-Эрдэнэ гишүүн “Би гар утсыг тагнаж, чагнадаг байгууллагын хүн биш. Хоёр хүн утсаар яриа л биз. Сонгуулийн дараа утсаар ярьсан л гэж байна билээ. Би ямар утсаар ярьсан биш. Тэгээд ч Ерөнхийлөгчийн сонгуульд манай нэр дэвшигч унасан нь үүнээс боллоо гэж нэг утасны яриагаар дүгнэж болохгүй шүү дээ. Б.Баатар гэдэг хүн манай ах. Гэхдээ бид хоёр хожим танилцсан ах, дүү хоёр. Бид хоёрыг танилцаж байх үед Х.Баттулга Ерөнхийлөгчтэй ойрхон ажиллаж байсан. У.Хүрэлсүх дарга “100 эрхэм”-д нь ороод, тэд найз л байсан шүү дээ. Тэгж ярих юм бол сонгуулийн үеэр “Бүрэн зураглал” энэ тэр гээд хамгийн их холбогдсон хүн нь М.Энхболд дарга өөрөө. Тэгвэл М.Энхболд дарга Б.Баатар хоёрын утасны яриаг гаргаж тавь л даа. Тэгээд ч Ерөнхийлөгчийн сонгуулиар МАН-ын нэг ч гишүүн намынхаа эсрэг ажиллаагүй. Үүнийг би хариуцлагатайгаар мэдэгдэв. Д.Амарбаясгалан даргын хэлдгээр хөлтэй нь хөлхөж, хөлгүй нь мөлхөж ажилласан. Ийм их хэмжээний хөрөнгө, цаг гаргасан сонгуулийг би өмнө нь үзээгүй. Би 10 гаруй жил идэвхтэй улс төрд ажиллаж байна. Ц.Нямдорж гуай, Т.Аюурсайхан, би гээд олон хүн тэргүүн эгнээнд гарч ажилласан. Сонгуулийн үеэр бүлх залгичихсан юм шиг байсан нөхдүүд сонгуулийн дараа бүлгтрээд байх хэрэггүй. Тухайн үедээ гараад ажиллахгүй яасан юм. Сонгуульд ялагдсан үндсэн шалтгаан бол М.Энхболд дарга УИХ-ын даргаар ажилласан нь. Та бүхэн санаж байвал би анх дарга болоход нь л эсрэг санал өгч байсан. Тэр хүн ард түмний энэ их итгэлийг Ерөнхий сайдаар ажиллаж, хариулах ёстой байсан юм” гэсэн байна.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



Монгол Улсын Ерөнхийлөгчийн Соёл, шашны бодлогын зөвлөх, Цооголгийн Хулан

“...I i i a i e ä n ä e i ö z i z n, n ä e ö a i ä y ð ä z e ä ä e ä ä p i . Ä ä ð ä ä, ö y ð ä e e i ä i i ð ö n ä ö ä z e ç ö ä ö z i z n, ö y ä i e e ä ä y i æ ä y ä i e i i ö z i y i ä ä e ä ä p i . Ç a n ä e e i ä ä ç a ð ö i ä ö ä ö ö e ä i ü ä n ä ä ð i ä ä ö ö e ä æ, ø e i y Ä ð ö i ö e e e ä ÷ e e i ö i ä ö i y ö ð ö e e ä n ä y ä ö y ö ö ÷ z z ö y i i ð i e ä e i ä ö ö ä ÷ e i ü ä z ö y ö ä z e ä y æ ö y e ü ä ...”

ДЭЛХИЙ

ОХУ-ЫН СУДАН ДАХЬ ЭЛЧИН САЙД УЧИР БИТҮҮЛГЭЭР НАС БАРЛАА



Б.ДАВАА

ОХУ-аас Суданд суух Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Миргаяс Ширинский тус улсын нийслэл Хартум хот дахь гэрийнхээ усан сангаас нас барсан байдалтай олджээ. Энэ талаар Судан болон ОХУ-ын албаны эх сурвалжууд хэвлэлд мэдээллээ.

Суданы Гадаад хэргийн яамны мэдэгдэлд "ОХУ-ын Элчин сайд өнөө шөнө Хароум хот дахь гэртээ нас барсан" гэж дурьдсан байна. Одоогоор үхлийн шалтгаан тодорхойгүй байгаа аж. Орон нутгийн цагдаагийн газраас "Франц пресс" агентлагт Элчин сайдын цогцсыг өчигдөр орой 19.05 цагт гэрийнх нь усан сангаас олсон гэж мэдэгдсэн байна.

Харин ОХУ-ын Гадаад хэргийн яамны мэдэгдэлд "чухам ямар шалтгааны улмаас Элчин сайд М. Ширинский амьсгал хураасан болохыг бид удахгүй судалж мэдсэнийхээ дараа олон нийтэд мэдээлэх болно" гэжээ.

Гэхдээ Элчин сайдын яамны ажилтны ярьж буйгаар талийгаач зүрхний шигдээс өвчнөөр таалал төгссөн байж магадгүй аж. Судан дахь Элчин сайдын яамны олон нийтэй харилцах хэлтсийн ажилтан Сергей Коняшин "Талийгаачийн усан сандаа амьсгал хураасан байхыг олж харсныхаа дараа шууд түргэн тусламж дуудсан. Гэвч, амийг нь аварч чадсангүй. Ерөнхийдөө сүүлийн өдрүүдэд зүрх нь өвдсөнөөс болж, нойргүйдэх шинж тэмдэг илэрч байсан" хэмээн "RT" агентлагт ярьсан байна. Дипломатчийн цогцос эдүгээ Хартум хотын морт хадгалагдаж байгаа аж. Улмаар хууль журмын дагуу ОХУ руу цогцсыг тээвэрлэж, түүнийхээ дараа оршуулгын ёслолын зохион байгуулах юм байна.

Эдүгээ ОХУ-ын хэвлэлд Элчин сайдын эмгэнэлийн мэдээлэл урсаж байгаа юм. М.Ширинскийн ар

...Гэхдээ Элчин сайдын яамны ажилтны ярьж буйгаар талийгаач зүрхний шигдээс өвчнөөр таалал төгссөн байж магадгүй аж. Судан дахь Элчин сайдын яамны олон нийтэй харилцах хэлтсийн ажилтан Сергей Коняшин "Талийгаачийн усан сандаа амьсгал хураасан байхыг олж харсныхаа дараа шууд түргэн тусламж дуудсан..."

гэрийнхэн, Оросын ард түмэн болон засгийн газарт Суданы Гадаад хэргийн яамнаас эмгэнэл илэрхийлсэн байна. М.Ширинский 1977 оноос хойш дипломат албан тушаалыг

хашиж иржээ. Тэрээр 1990-ээд оны эхээр Йеменд суух ОХУ-ын Элчин сайдын зөвлөх, Саудын Арабын Жеддах дахь ерөнхий консулаар тус тус ажиллаж байсан байна. Мөн 2006-2013 онд Зүүн Африкийн Рвандад Элчин сайдаар сууж байгаад 2013 оны арванхоёрдугаар сараас Судан дахь Элчин сайдаар томилогджээ. Тэрээр тус улсад очсоноосоо хойш ОХУ болон Суданы харилцааг бэхжүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргасан байна. Хамгийн сүүлийн жишээ дурьдахад, энэ онд Суданы Ерөнхийлөгч ОХУ-д өндөр төвшний айлчлал хийхээр бэлтгэж байжээ.

Энэ он гарсаар ОХУ-ын хэд хэдэн Элчин сайд зуурдаар таалал төгссөд байгаа юм. Зургаан сарын өмнө АНУ-д олон жил Элчин сайдаар ажилласан Витали Чуркин 64 насандаа зуурдаар таалал төгссөн юм. Мөн өнгөрөгч нэгдүгээр сард Энэтхэгт суух ОХУ-ын Элчин сайд Александр Кадакин 68 насандаа өвчний улмаас таалал төгссөн бол 2016 оны арванхоёрдугаар сард Туркид суух Элчин сайд нь ч гэмт этгээдэд буудуулж нас барсан билээ.

"Цэнхэр халим" тоглоом тоглосон гурван хүүхэд нас барлаа

Энэтхэгт өсвөр насны хүүхдүүд "Цэнхэр халим" тоглоомд автан амиа хорлох тохиолдол удаа дараа гарах болжээ. Улмаар аль хэдийнэ гурван хүүхэд амиа егүүтгэсэн байна. Тус тоглоомыг тоглосноор хэн нэгэн үл таних хүн интернэтээр "зааварчилгаа" өгдөг бөгөөд үүнтэй холбоотойгоор холбогдох албаныхан нийгмийн сүлжээнд тавих хяналт шалгалтаа чангатгаж эхэлжээ.

Орон нутгийн сонинд бичсэнээр, хэн нэгэн этгээд нийгмийн сүлжээгээр дамжуулан заавар өгч, харин тоглогчид түүнийг нь биелүүлэн, нотолгоо болгон зураг, бичлэгээ фэйсбүүк, инстаграмм хуудаастаа нийтлэх зарчмаар "Цэнхэр халим" тоглоом үргэлжилдэг байна. Тоглогчид 50 өдрийн хугацаанд өдөр бүр өөр өөр заавар авч, түүнийгээ биелүүлэх ёстой гэнэ. Тэдгээр зааварт нь "Өглөө 04.20 цагт босох", "чанга дуу хөгжим сонсох" гэх мэт хялбар чиглэл байх бөгөөд сүүлдээ "гарынхаа шууг хутгаар сийчих" зэргээр даалгавраа хүндрүүлдэг байна. Харин хамгийн сүүлчийн буюу

50 дахь өдрийн даалгавар нь "өндөр барилгаас үсрэх" байдаг гэнэ. Цэнхэр халим тоглоомыг тоглуулдаг этгээдүүд өсвөр насныхны нийгмийн сүлжээнд автсан байдал, өөрсдийгөө харуулах гэсэн хүслийг нь ашиглан тус тоглоомыг тоглуулдаг байна.

Энэтхэгт тоглоом тоглоод амиа хорлосон анхны тохиолдол долдугаар сарын 29-нд гарчээ. Тус улсын баруун этгээдийн Мумбай хотод 14 настай өсвөр насны хүүхэд зургаан давхар барилгаас үсэрч, амиа хорлосон байна. Түүнээс хойш нэг сарын дотор гэхэд Нью Дели, Керала мужид 10 гаруйхан настай өсвөр насны хоёр хүүхэд мөн л барилгаас үсэрч амиа хорложээ. Цагдаагийн алба хаагчид эдгээр тохиолдлуудыг "Цэнхэр халим" тоглоомтой холбоотой хэмээн үзэж, шалгаж эхэлсэн байна. Түүнчлэн, Нью Делигийн дээд шүүх энэ сарын 17-нд гүүгл, фэйсбүүк зэрэг компануудад хандан "Цэнхэр халим"-тай холбоотой мэдээлэл, линкийг устгаж байхыг шаарджээ.

Дашрамд дурьдахад, тус тоглоом ОХУ-д анх үүсч, дараа нь дэлхий даяар тархсан байна.

Кактус ирээдүйд эрчим хүчний эх үүсвэр болно

Мексикийн бэлгэдэл төрийгүй төрийн далбаанд нь хүртэл дүрслэгдсэн байдаг ургамал бол кактус. Тус ургамал эртний Ацтекийн эзэнт гүрний үед ариун ургамал гэж нэрлэгддэг байсан бол эдүгээ шууд уух болон жижиг хэрэглэх зориулалттай эмийн бүтээгдэхүүн, шампунь зэрэг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хэрэглэгдэх болсон байдаг. Гэвэл сүүлийн үед эрдэмтэд тод ногоон өнгөтэй кактусын шинэ ашиг тусыг нь судлан тогтоожээ. Тодруулбал, кактусыг сэргээдэх эрчим хүч гаргахад ашиглаж болох гэнэ. Кактусын хальсны гадаргуу хэсэг нь өргөстэй байдаг. Үүнийг нь өнөөдрийг хүртэл хог хаягдал мэт үзэж иржээ. Гэтэл судлаачид кактусны хальс, өргөс гэх мэт хэрэгцээгүй хэсгүүдийг



тариалангийн талбайд өнгөрөгч тавдугаар сараас био хий гаргах туршилт эхэлжээ. Милфа Альтагийн талбайд жил бүр 200 мянган тонн кактус ургадаг ч, үүний 10 тонн орчим нь хаягддаг байна. Харин үүнийг ашиглаж, хог хаягдлыг эрчим хүч болгон хувиргах био хий үйлдвэрийг орон нутгийн байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Suema" компани байгуулсан нь энэ аж.

"Suema" компани кактусын хаягдлыг ашиглан био хий үйлдвэрлэх үйлдвэрээ тус ургамлын талбайд түшиглэн байгуулсан байна. Тэд зах, худалдааны төвүүдэд хаягдаж буй кактусыг өмнөх өдөр нь түүн авчирч, био хийгээ үйлдвэрлэх аж. Энэ туршилтад нийтдээ 840 мянган ам.доллар зарцуулсан бөгөөд ихэнхийг нь Мехико хотын захиргаанаас гаргажээ.

"Suema" компанийн био хий гаргах байгууламж нь багадаа 9600 гэрлийн чийдэнг асааж дөнгөхөөс гадна цагт 175 кВт цахилгаан үйлдвэрлэх хүчин чадалтай аж. Ирэх арваннэгдүгээр сараас тус компани бүрэн хүчин чадалаараа ажиллахаар төлөвлөж буй юм байна. Ингэвэл нэг өдөрт 3-5 тонн хог хаягдлаар 170 шoo метр био хий болон нэг тонн гаруй бордоо үйлдвэрлэх гэнэ.

Амазонд усан онгоц живж, долоон хүн нас баржээ

Бразилийн Амазоны бус нутагт 70 зорчигч тээж явсан усан онгоц живсний улмаас долоон хүн амиа алджээ. "Лхагва гарагийн өглөө 25 хүнийг эсэн мэнд аварч чадсан" гэж "Пара мужийн Аюулгүй байдлын албанаас мэдээлсэн байна. Мөн таван том хүн, нэг өсвөр насны хүүхэд, нэг нялх хүүхдийн цогцсыг олжээ. Хэдэн арван хүн одоо болтол сураггүй хэвээр байгаа юм. Тус онгоц даваа гарагийн орой Сангарем хотоос гарч Пара мужийн Витория ду Шингуг зорин явж байсан бөгөөд Порто до Мозын эрэг орчимд живжээ. Орон нутгийн цагдаагийн албанаас ослын шалтгааныг тодруулахаар ажиллаж байна. Орон нутгийн албаныхны эрэл хайгуулын ажилд туслахаар тэнгисийн цэргийн албанаас онгоц, эргүүлийн усан онгоц зэргийг илгээжээ. Усан онгоцоор аялах явдал нь Бразилийн Амазоны бус нутгийн гол гол замуудын дагуу нийтлэг хэрэглэгддэг аялалын нэг ажээ.

Пхеньян АНУ-ыг хүндэлж эхэлсэн үү

АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп Аризона мужийн Фoenix хотод зохион байгуулагдсан уулзалтад оролцон нээлтийн үг хэлэхдээ Хойд Солонгосын удирдагч Ким Жон Ун АНУ-ыг хүндэлж эхэлсэн тухай дурьджээ. Нөгөөтэйгүүр, Төрийн нарийн бичгийн дарга Рекс Тиллерсон ч үүнээс өмнө Хойд Солонгосын эсрэг хоригтоо чангатгах шийдвэрийг НҮБ-ын

Аюулгүйн зөвлөлөөс гаргаснаас хойш үүссэн нөхцөл байдал сайжирч байгааг сайшаасан байдаг. Тэрбээр Пхеньянтай ойрын хугацаанд хэлэлцээрийн ширээний ард сууж магадгүй тухай үг унагаж байсан юм. Д.Трамп олон дэмжигчид нь хуран цугларсан талбайд үг хэлэхдээ өөрийнх нь эрс шийдэмгий, түрэмгий мэдэгдэл

бодит байдалд үр дүн авчирч байгааг мөн онцолжээ. Тэрбээр "Миний хэлсэн үгийг зарим хүмүүс хатуу гэж хэлдэг. Шууд ингэж хэлж болохгүй л дээ. Ким Жон Ун АНУ-ыг одоо хүндэлж эхэлж байгаа гэж бодож байна. Эсвэл үгүй ч байж мэднэ. Гэхдээ л миний хэлсэн үг ямар ч байсан эерэг үр дүн авчирсан" гэж ярьжээ.



Самсунг "Galaxy Note 8" утсаа танилцууллаа

сэтгэлээсээ та нартаа талархал илэрхийлье" гэсэн байна. Мөн "өмнөх загварынх шиг асуудал дахин давтагдахгүй" гэж мэдэгджээ. "Galaxy Note 8" утасны ар талд хос камер суурилуулсан бөгөөд ингэснээр зургийн чанар нь илүү сайжирчээ. Мөн дэлгэцний мэдрэгч дээр зураг зурж, үсэг бичих боломжтой "S pen"-ээр тоногдсон байна. Утасны урьдчилсан захиалга эдүгээ эхэлсэн байна. Харин дэлхий даяар есдүгээр сарын 15-наас худалдаанд гарах аж. Үнэ нь одоогоор тодорхойгүй байгаа ч, 850 ам.долларт хүрэх төлөвтэй байна. "Galaxy Note 8" нь Самсунгийн гол нэрийн бүтээгдэхүүн "Galaxy S8"-тай харьцуулахад илүү том дэлгэц, илүү дэвшилтэт функцүүдтэй, мөн "Galaxy S8"-тай ижил нугардаг атлаа илүү том буюу 6.3 инчийн амолд дэлгэцтэй гэдгээрээ онцлог юм байна.

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2017.08.25

Баянзүрх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендэрт оролцогчдоос **Баянзүрх дүүргийн гэр хороолол, нийтийн эзэмшлийн зам талбайд ариутгал, халдваргүйжүүлэл хийх ажил, БЗДХААА-17/519-ыг** гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг 2017 оны **09 дүгээр сарын 01-ний өдрийн 09 цаг 00 минут**-аас өмнө Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр, 1 давхарт 121 тоот хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендэрт оролцогчдыг байлцуулан **2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 09 цаг 20 минут**-д нээнэ.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Тендерийн баримт бичгийг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр **50000** төгрөгөөр худалдана. Мөнгө тушаах данс: Баянзүрх дүүрэг Төрийн сан Худалдан авах ажиллагааны алба 100200355027 Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол улс, Улаанбаатар-51
Баянзүрх дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө-57
13 дугаар хороо, Засаг даргын Тамгын газрын байр,
1 давхарт 121 тоот, Худалдан авах ажиллагааны алба Утас:70154446

СПОРТ



АНГЛИАС АНХ УДАА АВАРГУУДЫН ЛИГТ
ТАВАН БАГ ОРОЛЦОНО

VI нүүрт

РҮҮНИ АНГЛИЙН ШИГШЭЭГЭЭС
ЗОДОГ ТАЙЛЛАА

VI нүүрт

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

АМЖИЛТЫН ЭЗЭН

МУБИС хөлбөмбөгийн дасгалжуулагчийн ангитай болжээ

Шинэ хичээлийн жилээс эхлэн Монгол Улсын Боловсролын их сургуульд хөлбөмбөгийн дасгалжуулагчийн анги нээгдэж байгаа ажээ. Хоёрхон жилийн дотор мэргэжлийн хөлбөмбөгийн боловсролыг эзэмших боломж нээгдсэн нь Монголын хөлбөмбөгийн хөгжилд үнэтэй нэмэр болох нь дамжиггүй. Монголын хөлбөмбөгийн холбооны ерөнхийлөгч А.Ганбаатар 2017 оны дасгалжуулагчийн боловсролыг дэмжих жил болгон зарласны хүрээнд олон ажил хийж байгаагийн нэг нь эл анги нээгдэж байгаа явдал юм. Хэрэв та, таны хүү хөлбөмбөгийн дасгалжуулагч болох хүсэлтэй бол энэ ангид суралцахад боломжтой аж.

Г.Наранцэцэг, Б.Мягмардорж нар шагналт байрт шалгарлаа

Универсиад наадмын жүдо бөхийн тэмцээн өнгөрсөн лхагва гарагт өндөрлөлөө. Тэмцээний сүүлийн өдөр эмэгтэй 48, эрэгтэй 60 кг-ын барилдаан болж, манай хоёр бөх хоёулаа тавдугаар байрт шалгарлаа. Эмэгтэйчүүдийн 48 кг-ийн жинд Г.Наранцэцэг хэсгийн аваргын төлөө барилдаанд ОХУ-ын бөх Н.Перидсканатай таарч вазаригаар ялагдан, дагах барилдаанд шилжин Энэтхэгийн бөх Пулиеллумпурат Асвагыг иппоноор ялан улмаар хүрэл медалийн төлөө БНСУ-ын бөх Жеонг Бокеонгид вазари үнэлгээгээр ялагдсан. Тэгвэл эрэгтэйчүүдийн 60 кг-ийн жинд Б.Мягмардорж дагах барилдаанд АНУ-ын бөх Фукухара Аарон Хирошиг вазаригаар ялж, хүрэл медалийн төлөө Казакстаны бөх, Дэлхийн аваргын мөнгөн медальт Ибраев Рустамтай барилдан вазари үнэлгээ алдаж шагналт тавдугаар байрт шалгарсан юм.



П.Орхон

МОНГОЛЫН ЧӨЛӨӨТИЙН ТҮҮХЭН ДЭХ ТАВ ДАХЬ ДЭЛХИЙН АВАРГА БОЛЛОО

Үргэлжлэл.
Түүрч нь I нүүрт

Улмаар “Москва-2010” ДАШТ-ий хүрэл медальт, 2012 оны Европын аварга Шведийн Хенна Йоханссоньг 6:2-оор буулгаж авсан. Түүнтэй хийсэн барилдаан нэлээд хүн болсон. Гэхдээ манай бөх давуу байгаагаа харуулж, том бөхийг ялж чадсан юм. Тэгвэл 1/4 шигшээд Африк тивийн долоон удаагийн аварга Нигерийн Блессинг Оборудудуг цэвэр ялсан. Оноогоор хожиж яваад л цэвэр дарсан. Ерөөс энэ дэлхийн аваргад Негирийн бөхчүүд тун сайн байгаа. Оборуду ч гэсэн гайхалтай барилдаж, тавдугаар байрт шалгарсан. Манай бөхийн хувьд хагас шигшээд “Бээжин-2008”, “Лондон-2012” олимпын наадмын

хүрэл медальт Колумбийн Жаклин Рентериа Кастильог оноогоор цэвэр ялж, финалдсан юм. Колумбийн туршлагатай, алдарт бөхийг П.Орхон 13:0-ээр ялж, 63 кг-ын жинд дэлхийд шинэ “од” гарч ирж байгаа шүү гэдгээ улам ч тод томруун харууллаа. Харин алтан медалийн төлөөх барилдаанд ДАШТ-ий алт, хүрэл медальт, Европын хошой аварга Украины Юлия Ткачийг 6:3-аар ялснаар Монгол Улсын алтан соёмбот далбаагаа Парисын тэнгэрт мандуулав. Өдгөө 24 настай П.Орхон чөлөөт бөхийн дэлхийн аварга болсон Монгол Улсын тав дахь тамирчин болсон юм. Түүнээс өмнө хөдөлмөрийн баатар Зэвэгийн Ойдов “Стамбул-1974, Минск-1975”, Хорлоогийн Баянмөнх “Минск-1975”,

Соронзонболдын Батцэцэг “Москва-2010”, “Лас Вегас-2015”, гавьяат тамирчин Сүхээгийн Цэрэнчимэд “Ташкент-2014”-д дэлхийн аварга хэмээх эрхэм алдрыг хүртэж байсан билээ. Дашрамд дурьдахад, П.Орхон энэ жил зургаан тэмцээнд оролцоод, бүгдэд нь түрүүлээ. Тэр дунд “Алтан гран при”, тэгээд дэлхийн аварга багтаж байна. 63 кг-ын жинд 2015 онд Хөдөлмөрийн баатар С.Батцэцэг дэлхийн аваргад тасархай түрүүлж байсан. Бүр финалд Японы бөхийг цэвэр дарж байлаа. Тэгвэл П.Орхон энэ жил С.Батцэцэгийг хоёр ч удаа ялсан. Тэгэхдээ бүр оноогоор цэвэр ялж, илт илүү гэдгээ нотолсон юм. Тэр энэ жинд дэлхийн аваргад оролцох эрхээ гуйж биш гуудаж авсан. Тиймдээ ч монголчуудын итгэлийг

алдалгүй, бүх өрсөлдөгчөө давуу ялж, дэлхийнаваргагэдэгэрхцолыг хүртэж чадлаа. Эхний өдөр барилдсан манай бусад бүсгүйчүүдээс 55 кг-д “Хилчин” спорт хорооны тамирчин ОУХМ Эрхэмбаярын Даваачимэг найм, 58 кг-д “Хасу-Мегастар” клубийн тамирчин ОУХМ Алтанцэцэгийн Батцэцэг 12, 75 кг-д “Хилчин” спорт хорооны тамирчин ОУХМ Ган-Очирын Уртнасан наймдугаар байр эзэллээ. Эхний өдөр 55 кг-д алдарт Саори Ёшидагийн залгамжлагч гэгддэг буй Японы 18 настай охин Харуна Окуно, 58 кг-д “Рио-2016” олимпын наадмын аварга, ДАШТ-ий алт, мөнгө, хүрэл медальт АНУ-ын алдарт бөх Хелен Марулис, 75 кг-д энэ жилийн Европын аварга Туркийн Ясемир Адар нар түрүүлээ.

Хаданд авиралтын УАШТ болно

Хаданд авиралтын спортын улсын аварга шалгаруулах тэмцээн энэ сарын 26, 27-нд болох ажээ. Энэхүү тэмцээн Төв аймгийн Борнуур суманд байрлах Дуган хаданд болох юм байна. 47 дахь удаагийн тэмцээнийг Олон улсын хэмжээний мастер Д.Чадрабал агсны нэрэмжит болгон зохион байгуулах аж. Тэмцээн хурд, техник гэсэн хоёр төрлөөр болно. Хурдны төрөл өсвөр (8-13 нас), залуучууд (14-19 нас), насанд хүрэгчид (20-35 нас), ахмад нас (36-аас дээш нас) гэсэн ангиллаар болох аж. Харин техникийн төрөл залуучууд (14-19 нас), насанд хүрэгчид (20-35 нас), ахмад нас (36-аас дээш нас) гэсэн гурван төрөлд зохион байгуулагдах ажээ.

ӨӨРӨӨС НЬ

Б.ЖАНЧИВДОРЖ: Жүдогийн татамигаас буухаараа үндэсний бөхөөр барилдана даа

Н.ПУНЦАГБОЛД

АНУ-ын Лос-Анжелос хотноо энэ сарын 7-17-ны өдрүүдэд Дэлхийн цагдаагийн спортын наадам болсон билээ. Энэхүү наадамд жүдогийн төрлөөр оролцож, мөнгөн медаль хүртээд ирсэн цагдаагийн ахлах ахлагч Б.Жанчивдоржтой ярилцлаа. Тэрбээр 2017 оны Жүдо бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээний 100 кг-ын жинд түрүүлсэн тамирчин юм.

-Дэлхийн цагдаагийн

спортын наадамд амжилттай оролцож, мөнгөн медаль хүртсэн. Энэ удаагийн Цагдаагийн олимп ямархуу болов? -Энэ жил Цагдаагийн олимп болж эхэлсний 30 жилийн ой тохисон. Тэр утгаараа зохион байгуулалтуурьд жилүүдийнхээс өргөн хүрээг хамарч, олон орны тамирчид оролцсон. Ерөөс улс болгон л өргөн бүрэлдэхүүнтэй баг илгээсэн байсан. Хамгийн олон хүнтэй нь Хятадын баг 1000 орчим тамирчны бүрэлдэхүүнтэй оролцсон. Мөн Энэтхэг, АНУ-ын багууд олон хүний бүрэлдэхүүнтэй байсан.

Манай улс ч гэсэн 2015 оныг бодвол олуулаа, 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй явсан. Спортын 6, 7 төрөлд оролцсон. Харин манай баг тамирчид 14 алт, есөн мөнгө, 12 хүрэл медаль авсан. Очсон бүх тамирчин медальтай ирсэн гэж хэлж болно. -Барилдааныхаа тухай ярьвал? -Би Бразил, Оросын тамирчин ялаад, аваргын төлөө Германы бөхөд хожигдсон. Тэмцээнд явахдаа л гарандаа бага зэргийн бэртэлтэй байсан. Очоод тэмцээнд ороход бэртэл сэдэрч, мөр мултгарсан. Үнэхээр хүнд барилдаануудыг хийсэн.

Финалд Германы бөхтэй хийсэн барилдаан бүр хүнд байсан. Мөрөнд өвчин орчихсон байсан болохоор барилдаан сайн гарч өгөөгүй. Тэгээд л мөнгөн медаль хүртсэн дээ. -Цагдаагийн спортын наадамд оролцоход эрх авна гэж байх уу. Ямар шалгуураар орох вэ. Заавал цагдаагийн байгууллагад ажилладаг байх ёстой гэсэн шаардлага тавих уу, үгүй юу? -Жил болгон “Хүч” спорт хорооны тамирчдынхаа дунд тэмцээн зохион байгуулдаг. “Цагдаа-95, 96, 97” гэсэн нэртэй тэмцээн болно. Тэр тэмцээнд түрүүлсэн тамирчдыг оруулдаг. Энэ жил цагдаагийн байгууллага хүндийн өргөлт, жүдо, пауэрлифтинг, мотоспорт, чөлөөт болон сонгомол чөлөөт бөх, бокс, жүдо, жюу жицу, каратэ гэх амжилт гаргах боломжтой гэсэн төрлүүдэд тамирчид явуулсан. Хол болсон болохоор зардал мөнгөний асуудал тулгарсан. Тэр болгон олон тамирчны бүх зардлыг гаргаад байх боломжгүй. Тийм болохоор Цагдаагийн Ерөнхий газраас тал зардлыг нь гаргасан.

Үргэлжлэл нь VII нүүрт

ХӨЛБӨМБӨГ



“ПСЖ” Мбаппегийн төлөө 150 сая дээр нэг тоглогч нэмж өгнө

“Монако” клубын довтлогч Килиан Мбаппе “ПСЖ” клубт замналаа үргэлжлүүлэхээр боллоо. Учир нь хоёр тал нэгэнг тохиролцоонд хүрсэн бөгөөд “ПСЖ” түүний төлөө 150 саяг өгөөд нэмж нэг тоглогч “Монако” руу явуулах аж. “ПСЖ” Неймарыг “Барселона”-гаас 222 сая еврогоор худалдаж авсан. Тэгвэл Европын хөлбөмбөгийн холбооноос санхүүгийн шударга өрсөлдөөнийг зөрчсөн гэсэн шийтгэл авахгүйн тулд нэг тоглогчоо дуртайгаар явуулах гэж байгаа юм байна. “ПСЖ” Серж Орье, Хатем Бен-Арфа, Грезгорз Крыховик, Лукас Моура, Анхель Ди Мария, Жулиан Дракслер, Гонзало Гедеш гэсэн тоглогчдыг явуулах хүмүүсийн тоон багтаагаад байгаа билээ.

Рүүни Английн шигшээгээс зодог тайллаа

“Эвертон”-ы довтлогч Уэйн Рүүни Английн шигшээд дахин тоглохгүй гэсэн шийдвэр гаргаснаа албан ёсоор зарлалаа. Английн шигшээ багийн түүхэн шилдэг мэргэн буучаар нэрлэгддэг Уэйн Рүүни шигшээд нийт 119 тоглолтод оролцож, 53 гоол оруулсан юм. Тэрбээр зодог тайлах талаараа мэдэгдэх үедээ “Энэ долоо хоногт шигшээгийн дасгалжуулагч Гарет Саутгейт над руу утасдаж, шигшээдээ харахыг хүсч буйгаа хэлсэн нь таатай санагдсан. Гэвч би энэ талаар удаан хугацааны турш сайтар бодсон тул шигшээд дахин тоглохгүй гэдгээ Гаретад хэлсэн. Хэн хэндээ энэ нь дээр байх болно.

Шийдвэр гаргах хэцүү байлаа. Гэр бүлийнхэнтэйгээ, “Эвертон”-ы дасгалжуулагчтай, ойр дотныхонтойгоо зөвлөлдөж байж би ийм шийдвэр гаргасан. Шигшээдээ тоглоно гэдэг миний хувьд үргэлж онцгой байдаг байлаа. Гэвч одоо явах цаг нь болжээ” хэмээсэн байна.



Англиас анх удаа Аваргуудын лигт таван баг оролцоно

Н.ПУНЦАГ

Европыхамгийн нэрхүндтэй тэмцээн болох Аваргуудын лигийн 2017-2018 оны улиралд өрсөлдөх шилдэг 32 багийн нэр эцэслэн тодорлоо. Өнгөрсөн мягмар, лхагва гарагийн шөнө урьдчилсан шатны харуу тоглолтууд болж, 10 баг эрхээ авсан юм. Тэр дундаа Английн “Ливерпүүл” клуб Аваргуудын лигт оролцох эрхээ авсан. Ингэснээр Англиас анх удаагаа Аваргуудын лигт таван баг оролцохоор боллоо. Өнгөрсөн улиралд “Челси” премьер лигт түрүүлж, “Тоттенхэм”, “Сити” удаалсан. Ингэснээр шууд Аваргуудын лигт оролцох эрхээ авсан юм. Тэгвэл “Манчестер Юнайтед” клуб Европын лигт түрүүлснээр эрхээ авч чадсан билээ. “Ливерпүүл”-ийн хувьд дөрөвдүгээр байраар лигийг өндөрлүүлсэн учир плей-офф шатны тоглолт хийхээр болсон. Тэд урьдчилсан шатанд Германы “Хоффенхайм” клубтэй учраа таарч, хоёр тоглолтын нийлбэр дүнгээр 6:3-аар буулган авч, Аваргуудын лигт оролцох эрхээ авсан юм. Хоёр багийн харуу тоглолт өнгөрсөн лхагва гарагийн шөнө Англид болоход “Ливерпүүл” өрсөлдөгчөө 4:2-өөр “шүүрдэж”, Европын тавцанд өрсөлдөхөд бэлэн гэдгээ харуулсан. Жан энэ тоглолтод хоёрыг оруулж, Салах, Фирмино хоёр нэг нэгийг нэмсэн юм. Энэ улирлын Аваргуудын лигт Англиас таван

баг оролцоно гэдэг утгаараа тэд сайн өрсөлдөх байх. Тэгээд ч Английн хамгийн том багууд Аваргуудын лигт эргэж ирлээ. “Арсенал”-ыг эс тооцвол. Тэгвэл Испаниас дөрвөн баг оролцоно. “Реал Мадрид”, “Барселона”, “Атлетико Мадрид” шууд эрхээ авсан. Харин “Севилья” урьдчилсан шатанд Туркийн “Истанбул” багийг хоёр тоглолтын нийлбэр дүнгээр 4:3-аар буулгаж авч, Европын тавцанд өрсөлдөх эрхээ олж авч байгаа юм. Герман улсаас “Байерн Мюнхэн”, “Боруссия Дортмунд”, “Лейпциг” гэсэн гурван баг оролцоно. “Хоффенхайм” урьдчилсан шатанд хожигдсон. Италиас “Ювентус”, “Рома”, “Наполи” гэсэн гурван баг оролцохоор боллоо. “Наполи” мөн урьдчилсан шатнаас эрхээ авсан. Тэд Францын “Ницца”-г

хоёр тоглолтын нийлбэр дүнгээр 4:0-ээр буулгаж авсан билээ. Францын лигээс “Монако”, “ПСЖ” гэсэн хоёр баг Аваргуудын лигт тоглохоор боллоо. Харин Португалиас “Бенфика”, “Порто”, “Спортинг” гэсэн гурван баг орж ирж байна. Оросын лигийн хувьд “Спартак”, “ЦСКА Москва” гэсэн хоёр баг эрхээ авч чадлаа. Харин бусад эрхийн тухайд Украинаас “Шахтёр”, Швейцариас “Базель”, Грекээс “Олимпиакос”, Бельгийс “Андерлехт”, Туркээс “Бешикташ”, Голландаас “Фейноорд”, Словенаас “Марибор” багууд оролцоно. Мөн Кипрээс “АПОЭЛ”, Шотландаас “Селтик” клубүүд нэмэгдэж байгаа юм. Тэгвэл Азербайжанаас “Карабах” клуб анх удаа Аваргуудын лигт оролдож, багийнхаа түүхэн

дэх нэгэн шинэ хуудсыг нээж байна.

Аваргуудын лигийн шинэ улирлын сугалаа өнгөрсөн шөнө болсон байх ёстой. Харин сугалааны өмнө багууд дөрвөн сагсанд хуваагдсан. Английн “Тоттенхэм”, “Ливерпүүл” клубүүд гуравдугаар сагсанд орсон нь хэсгийн тоглолтуудыг маш хүнд болгож байгаа юм. 2-3 хэсэг “Үхлийн” гэх тодотголтой болох биз ээ.

Хэсгийн сугалааны сагсанд багууд хэрхэн хуваагдсаныг та бүхэнд толилуулж байна

- Карс 1:** “Реал Мадрид” Испани, “Байерн Мюнхен” Герман, “Челси” Англи, “Ювентус” Итали, “Бенфика” Португал, “Монако” Франц, “Спартак Москва” ОХУ, “Шахтер” Украин.
- Карс 2:** “Барселона” Испани, “Атлетико” Испани, “ПСЖ” Франц, “Боруссия Дортмунд” Герман, “Севилья” Испани, “Манчестер Сити” Англи, “Порто” Португал, “Манчестер Юнайтед” Англи
- Карс 3:** “Наполи” Итали, “Тоттенхэм” Англи, “Базель” Швейцарь, “Олимпиакос” Грек, “Андерлехт” Бельги, “Рома” Итали, “Бешикташ” Турк, “Ливерпүүл” Англи.
- Карс 4:** “Фейноорд” Голланд, “Марибор” Словен, “РБ Лейпциг” Герман, “ЦСКА” ОХУ, “Карабах” Азербайжан, “АПОЭЛ” Кипр, “Спортинг” Португал, “Селтик” Шотланд.

“Барселона” Неймарыг шүүхэд өгсөн явдлыг ОУХХ шалгаж эхэллээ

“Барселона” клуб багийн шилдэг тоглогч Неймарыг Францын “ПСЖ” рүү 222 сая еврогоор зарсан билээ. Тэгвэл энэ наймаатай холбоотой дуулиан шуугиан одоо болтол үргэлжилсээр байна. Учир нь Каталонь баг бразил довтлогч Неймарыг гэрээ зөрчсөн гэсэн үндэслэлээр нийтдээ 18.5 сая евро нэхэж, шүүхэд хандсан. Хэрвээ Неймар энэ мөнгийг төлөхгүй бол ПСЖ-ээр төлүүлнэ гэж “Барселона”-гийн мэдэгдэлд дурьдсан байсан. Харин энэ хэрэг явдлыг Олон Улсын Хөлбөмбөгийн Холбоо албан ёсоор шалгаж эхэлсэн гэнэ. “ОУХХ хэргийн бүх мэдээллийг шалгаж эхэлсэн. Мөдхөн шийдвэр гаргана” гэж ОУХХ-ны хэвлэлийн төлөөлөгч мэдэгдсэн байна. Үүнээс өмнө “Барселона”-гийн төлөөлөгч Жорди Вивес “Неймар гэрээний гурван нөхцөлийг огт биелүүлээгүй. Тэр сүүлийн гурван сарын хугацаанд өөр клубт очих талаар хэлэлцээр хийх эрхгүй байсан. Тиймээс бид нэмэлт урамшууллыг олгохгүй” гэж мэдэгдсэн юм.

Нэмэлт урамшуулал гэдэг нь өнгөрсөн жил Неймарын гэрээг сунгахад эцэгт нь урамшуулал болгож 26 сая евро өгнө гэж гэрээнд заасан асуудлыг хэлж байна.



“Ливерпүүл” Хеведесийг 20 саяар авахад бэлэн

Германы “Шальке” клубын төвийн хамгаалагч Бенедикт Хеведес цөөнгүй багийн анхаарлын төвд орчихоод байгаа аж. Эдүгээ 29 настай Герман эрийн төлөө “Ювентус” болоод “Ливерпүүл” клубүүд 20 сая евро төлөхөд байгаа аж. “Улаанууд”

“Саутгэмптон”-ы хамгаалагч Виргил ван Дейкийг авахаар сонирхож байгаа. Гэхдээ түүнээс өөр сонголт хийж ч магадгүй байгаа нь Хеведес юм байна. Хеведес “Шальке”-гийн ахлагч байж байгаад болсон. Тэрбээр багтайгаа 2020 он хүртэл гэрээтэй ажээ.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдөр.

Тендер шалгаруулалтын нэр: Сүхбаатар сумын уурын зуухны барилгын ажил, гадна дулаан, цэвэр усны шугамын ажил]-ын гүйцэтгэлийг сонгон шалгаруулах. Тендер шалгаруулалтын дугаар: СҮАСБСЗДТТ/201708020

Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Сүхбаатар сумын уурын зуухны барилгын ажил, гадна дулаан, цэвэр усны шугамын ажил]-ыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50.000,0 (Тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.Үүнд:

- Сүүлийн 3 жилийн буюу 2014, 2015, 2016 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
- Сүүлийн 3 жил буюу 2014, 2015, 2016 онуудын санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ.
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас доошгүй байна.
- Сүүлийн 3 жилийн дундаж нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байна. Ажил гүйцэтгэх гэрээ, хүлээлгэж өгсөн улсын комиссын актыг хавсаргана.

Дараах тусгай зөвшөөрөл шаардлагатай:

- 2.1.1 Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил, Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн барилгын ажил(1-5 давхар хүртэл)
- 2.1 Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
- 2.2 Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт
- 2.2.4 Дулааны болон усан хангамжийн гол (магистраль)шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт

Түншлэл болон туслан гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэх ажил үүргийн дагуу тусгай зөвшөөрөлтэй байна.

Тендерийн хамт дараах дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Тендерийн баталгааны дүн: 10,000,000 (Арван сая) төгрөг Тендерийг 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байшуулан тендерийг 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 09 цаг 30-минутад нээнэ. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй. Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

[Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум, 7-р баг Нутгийн удирдлагын ордон 3-н давхар, Орон нутгийн өмчийн газар, 306 тоот өрөө (мэргэжилтэн С.Бат-Өлзий, Утас:70518123, 89151515)]

СПОРТ

ӨӨРӨӨС НЬ

Б.ЖАНЧИВДОРЖ: Жүдогийн татамигаас буухаараа үндэсний бөхөөр барилдана даа

Үргэлжлэл.
Түүрүүч нь V нүүрт

Тамирчид өөрсдөө үлдсэнийг гаргана. Гэхдээ хувиасаа гаргачихгүй л дээ. Харьяа, анги нэтгэлээс л зохицуулж өгч, тусална шүү дээ. Би гэхэд л Хан-Уул дүүргийн цагдаагийн газраар ивээн тэтгүүлж, зардлаа зохицуулж явсан. Цагдаагийн спортын наадамд ороход эрх авна гэсэн юм бол байхгүй. Зохион байгуулж байгаа орноос тамирчдаа оролцуулаач гэсэн урилга ирдэг юм билээ. Тэгээд тухайн улс өөрсдөө ямар тамирчныг, аль төрөлд оруулах вэ гэдгээ шийднэ. Оролцож байгаа тамирчид бол бүгд л цагдаа, хүчний байгууллагад ажилладаг, харьяалагддаг юм билээ. Гэхдээ тэр дунд олон улсын тэмцээн уралдаанд оролцдог шилдэг тамирчид ч байсан.

-Цагдаагийн олимп гэгддэг учраас нэр хүнд, цар хүрээ томтой байх л даа. Тиймдээ ч шилдэг тамирчид олон оролцож байгаа байх?

-Бүхий л улс оронд цагдаа, хүчний байгууллага байгаа. Тийм болохоор цагдаагийнхаа байгууллагад ажилладаг, харьяалагддаг тамирчдыг тэмцээнд оролцуулж, тухайн улсын цагдаагийн байгууллагыг дэлхий нийтэд таниулж байгаа хэрэг. Манай улс ийм цагдаатай, тамирчинтай. Байнга ажлаа хийгээд байх. Ажлынхаа хажуугаар бэлтгэл сургуулилтаа хийгээд, ийм амжилт үзүүлж чаддаг шүү гэдгийг л харуулах зорилготой тэмцээн гэж санадаг. Сая бол манай баг бүрэлдэхүүн оролцсон төрөл бүртээ амжилт гаргаж, ямархуу чадвартай вэ гэдгээ харуулж чадлаа.

-Энэ жил жүдо бөхийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд -100 кг-д түрүүлсэн. Улсын аваргын талаар эргээд нэг дурсаач?

-Энэ жил улсын аваргадаа түрүүлж чадсан. Улсын аваргынхаа өмнө бэлтгэл сургуулилтаа сайн базаасан. Гэхдээ ажлаа ч бас хийж байсан. Би Хан-Уул дүүргийн Замын цагдаагийн хэлтэст цагдаа-зохицуулагчаар ажилладаг. Ажлынхаа хажуугаар бэлтгэлээ базааж байгаад л улсын аваргад оролцоод, түрүүлсэн дээ. Би чинь ажилдаа явна, зам дээр зогсч замын хөдөлгөөн зохицуулна. Түүнийхээ хажуугаар зав гаргаад л бэлтгэлээ хийнэ дээ. Үдээс хойш ажилтай бол өглөө нь бэлтгэлээ хийнэ. Өглөө ажилтай бол үдээс хойш бэлтгэлээ хийчихээд л зохицуулчихдаг.

-Улсын аваргад түрүүлсэн тамирчин бол шигшээ багт багтаж, гадаад руу тэмцээнд явдаг. Энэ жил бас Азийн аваргад хүрэл медаль авсан. Тийм болохоор жиндээ дэлхийн аваргад оролцох болов уу ч гэж харж байлаа?

-Улсын аваргад түрүүлснийхээ дараа Азийн аваргад явсан. Очоод хүрэл медаль хүртсэн. Дэлхийн аваргад оролцохыг бас бодолгүй л яхав. Гэхдээ энэ удаад Цагдаагийнхаа спортын наадамд явах зорилготой байсан болохоор боломж гарсангүй. Манай Цагдаагийн олимп чинь хоёр жилд нэг удаа болдог юм. Жүдогийн дэлхийн аварга Будапешт болно. Манай шигшээ багийнхан бэлтгэлээ хийж байгаа. Хэзээ модгүй л эх орноосоо мордох байх. Манай жинд жингийн дүү Л.Отгонбаатар барилдана. Олимпын тавдугаар байрын шагналтай, сайн бөх шүү дээ. Би уг нь 2007 оноос хойш шигшээ багт найман жил тамирчин байсан. 2015 он хүртэл гэсэн үг. Түүнээс хойш "Хүч" спорт хорооноос Замын цагдаа руу шилжээд, тэндээ харьяалагдаад явж байна. Ер нь бол шигшээ баг дээрээ очоод л бэлтгэл

хийдэг. Энэ жил Цагдаагийн олимп наймдугаар сард байсан болохоор "Хүч" спорт хорооныхонтойгоо бэлтгэлээ хийгээд л, тэмцээндээ явсан. Энэ жилийн тухайд байнгын бус болон байнгын гээд хоёр шигшээ багийг улсын аваргын дараа зарласан шүү дээ. Би байнгын бус шигшээд харьяалагдаж байгаа. Цалин мөнгө бол авахгүй. Харин уралдаан тэмцээнд явж болно.

-Ямар ч спортоор хичээллэж байгаа тамирчны гол зорилго бол олимп, дэлхийд амжилт гаргах болчихоод байна. Хэрвээ эдгээр тэмцээнд амжилттай оролцвол шагнал, урамшуулал нь амьдралд хэрэгтэй шүү дээ. Өөрт чинь ийм зорилго бас байдаг л

зохицуулаад, бусад үед нь бэлтгэлээ хийгээд л явдаг байх нь. Жүдо бөхийн шаггүй тамирчин хүн замын хөдөлгөөн зохицуулаад, дүрэмт хувцастай явж байна гэхээр бас л сонирхолтой санагдаж байна шүү?

-Тэгээд ажилтай үедээ ажлаа хийгээд, замын хөдөлгөөнөө зохицуулна шүү дээ. Миний ажил л юм чинь. Хүмүүс энэ жил намайг улсын аваргад түрүүлэхээр гайхаад байсан. Голдуу л ажлаа хийж харагдаад байсан юм чинь. Тэгтэл бараг бэлтгэл хийхгүй байж байгаад түрүүлчихлээ. Азаар түрүүлсэн гэж хэлэх нь холгүй байсан. Би бол ажлынхаа хажуугаар бэлтгэлээ зохицуулаад, байнга л хийгээд яваад байгаа шүү дээ. Манай цагдаагийнхан чинь

...Нөгөө хэд дээрээ очоод, тусалж дэмжээд, бэлтгэлийг нь хангалцаад явах байлаа. Харамсалтай нь мөр бэртэлтэй. Мултарчихсан юм. Америкт мултарсан мөрөө оруулж чадаагүй. Энд ирж байж оруулсан. АНУ-ын эмч нар чинь заавал шинжилгээ авч, нарийн сайн мэдэж байж эмчилдэг юм байна. Тийм болохоор энд ирээд л оруулсан...



байлгүй?

-Бэртлээ гайгүй болгочихоод, бэлтгэл сургуулилтаа сайн хийж байгаад, 2018 оныхоо улсын аваргад гайгүй оролцохоор хичээнэ дээ. Манай Замын цагдаагийн ажил чинь онцлог, ачаалал ихтэй. Цагдаагийн албан хаагчид чинь өглөө гараад л орой харьдаг. Бэлтгэл сургуулилт хийх цаг зав хязгаарлагдмал. Байнгын бэлтгэлтэй бөх, ажлынхаа хажуугаар бэлтгэл хийх хоёр чинь өдөр шөнө шиг л ялгаатай. Тэгээд ч спорт чинь залуу насны л ажил шүү дээ. Би одоо 31 настай настай. Хөгшрөх хандлагадаа орчихсон байна. Тийм болохоор үүрэгт ажлаа хийгээд, хажуугаар нь бэлтгэлээ базаагаад л явж байгаа нь энэ шүү дээ. Ер нь бол бусад тамирчдын л адил дэлхийн аваргад, Олимпын наадамд амжилт үзүүлэхийг хүсэлгүй яхав. Гэхдээ одоо нас явчихлаа. Дороос залуу сайн тамирчид гарч ирж байна. Тийм болохоор маш сайн байж гэмээн л тэдний урдуур дайрч явна. Манай "Хүч" спорт хорооноос тэмцээн уралдаан дөхөхөөр чөлөө өгнө. Тэр үедээ бэлтгэлээ сайн базаана. Тийм л байдлаар бэлтгэлээ хийж явдаг. Гэхдээ яах вэ, боломж бүхнээ дайчлаад, тэмцээн уралдаандаа оролцоно.

-Одоо тэгээд ажилтай үедээ замын хөдөлгөөнөө

их дэмжинэ ээ. Тэгээд Азийн аваргаас медаль аваад ирэхээр "Чи байнга л ажлаа хийж харагдсан. Хэдий завандаа ажлаа хийгээд, хэзээд нь бэлтгэлээ хийгээд, амжилт гаргаад байгаа юм бэ" гээд л гайхдаг. Би чинь Азийн аваргад явахдаа хоёр сарын өмнөөс ажлаасаа чөлөөлөгдөөд, шигшээ багт очиж, нэгдсэн журмаар бэлтгэлд хамрагдаад л явсан.

-Шигшээ багийнхан бэлтгэлээ базааж байгаа. Бэртэл авчихаагүй бол очиж бэлтгэл хангалцах л байсан байх даа?

-Нөгөө хэд дээрээ очоод, тусалж дэмжээд, бэлтгэлийг нь хангалцаад явах байлаа. Харамсалтай нь мөр бэртэлтэй. Мултарчихсан юм. Америкт мултарсан мөрөө оруулж чадаагүй. Энд ирж байж оруулсан. АНУ-ын эмч нар чинь заавал шинжилгээ авч, нарийн сайн мэдэж байж эмчилдэг юм байна. Тийм болохоор энд ирээд л оруулсан.

-Дэлхийн аваргад ер нь оролцож байсан бил үү?

-2011 онд Парист болсон дэлхийн аваргад оролцож байлаа. Эхний тойрогтоо Казахстан тамирчинд ялагдаад л өнгөрсөн. Тухайн үедээ 90 кг-д оролцож байсан юм. Ер нь тухайн үед жүдо бөхийн хөгжил шинэ төвшин рүүгээ явж л байлаа. Тийм болохоор



эрхээ авахад хүртэл тийм амар байсангүй. Тиймдээ л нэг л удаа дэлхийн аваргад оролцсон. Одоо бол манай жүдо бөх үнэхээр сайжирч байна. Шилдэг тамирчид ч гарч ирж, жин болгонд сайн барилддаг залуучууд байна.

-Нас 35 руу дөхөх тусам жүдоогоос зодог тайлах л болох байх. Түүнээс цаашаа юу хийх вэ. Спортоосоо хөндийрнө гэж байхгүй байлгүй дээ. Нэгийг төлөвлөж л байгаа байх?

-Үндэсний бөхөөр хичээллэж үзье л гэж бодож байгаа. Үндэсний бөхөөр сумын заан цолтой. Өмнө нь аймгийн наадамд ч барилдаж байгаагүй л дээ. Сумын наадамдаа л барилдаж байсан. Гэхдээ үндэсний бөхөөр 40 хүртэл барилдах боломжтой шүү дээ. Тэгээд жүдо бөхөөр хичээллэж байсан хүнд жингийн тамирчид үндсээр гайгүй

барилддаг. Н.Батсуурь арслан, Н.Түвшинбаяр заан, Э.Энхбат начин гээд жүдоогоор барилдаж байсан, цолонд хүрсэн бөхчүүд байна даа.

-Зам дээр хөдөлгөөн зохицуулах, тэмцээнд оролцох хоёрыг харьцуулаад нэг яриа ч. Бүр сонирхолтой санагдаад байна?

-Зам дээр зогсч, хөдөлгөөн зохицуулна гэдэг чинь амаргүй шүү дээ. Өвөл, зунгүй л зогсоно. Улаанбаатар хотын зам нарийн, тээврийн хэрэгслийн тоон хэтэрхий олон болчихсон болохоорхэцүүхэцүү.Тэмцээнд оролцох, тэгээд медаль хүртэх, түрүүлэх гэдэг чинь сайхан шүү дээ.

-Замын цагдаад хэзээ орсон юм бэ. Яаж яваад орчихов?


-Би 2006 онд "Хүч" спорт хороонд тамирчнаар орж байсан. Түүнээс хойш 2014 он хүртэл тэндээ харьяалагдаж

байгаад, өнөөдрийг хүртэл Хан-Уул дүүргийн замын цагдаад ажиллаж байна даа. "Хүч" спорт хороонд бол тамирчин байсан болохоор өөр ажил хийдэггүй байсан юм. Гэтэл "Хүч" спорт хороонд байсан тамирчдыг ийнш тийш хуваарилсан. Тэгээд л Хан-Уулын замын цагдаад очсон. Одоо бол бэлтгэлээ хийгээд, ажлаа хийгээд л явна даа.

-Сүүлчийн асуултыг танд үлдээ?

-Цагдаагийн олимпын наадамд явахад Цагдаагийн Ерөнхий газар тусалж, зардал мөнгө гаргаж өгсөн. Мөн Хан-Уул дүүргийн Замын цагдаагийн албан хаагчид маань ивээн тэтгэж, зардал мөнгө гаргаж өгч тусалсан. Тиймээс нийт цагдаагийнхаа бие бүрэлдэхүүнд баярлаж, талархсанаа илэрхийлье. Алба бүхэн сайхан шүү гэж хэлмээр байна даа.

ЗАВСАРЛАГА



“Нол” буланд тавтай морил

ИХ ГЭРИЙН ЭЗЭГТЭЙ

Үргэлжлэл.
Түүрч нь №140 дугаарт

Жеми маргааш нь ажил олов. Нэг пүүсийн бараа таваарыг тэргээр зөөх болсон байна. Хоёр хоногийн дараа нэг зоогийн танхимд оройн хоолноос хойш сав суулга угаах ажил хийх болов. Ширээн дээр үлдсэн хоолны үлдэгдлийг зочид буудалдаа авчирч хооллодог байлаа. Эндэхийн хоол нь нэг л хачин амттай. Жеми ээжийнхээ хийж өгдөг тахианы махтай шөл, шинэхэн халуун талх, овьёосны гурилан бинг санах болов. Гэсэн ч чухам хэрэгтэй багаж хэрэгсэл худалдан авах мөнгө хураах гэж тохь тух алдах, дасаагүй хоол идэхийг үг дуугүй тэсвэрлэж байв. Замаа нэгэнт сонгож авсан болохоор эцэж туйлдаглаа ажил хийх, өмхий агаараар амьсгалах, хар ялаа шөнө унтуулахгүй шавхин аль нь ч түүнийг зогсоож чадахгүй. Харин Жеми муухай их ганцаардаж байлаа. Энд таних мэдэх хүн нэг ч байхгүй тул сайн нөхөд, гэр орноо санан уйтгарлана. Жеми уг нь ганцаар байх дуртай. Гэвч энд ганцаардахын зовлон эдэлж байв. Тэгсэн уртгал хүсэн хүлээсэн өдөр нь болж, түрийвчиндээ хоёр зуун фунттай болж, замд ороход бэлэн боллоо. Маргаашнаас алмас эрдэнийн талбай руу явна. Клипдрифт дахь алмасын уурхай руу очдог суудлын мухлаг тэргэний тасалбарыг “Инланд Транспорт” компани гэсэн хаягтай жижиг модон байшинд худалддаг ажээ. Жемийг өглөөний 07:00 цагт тэнд очиход өдий төдий хүн шавааралдаад кассанд нь дөхөж очихын ч аргагүй байв. Азаа үзэх гэсэн олон зуун хүн мухлагт суух эрхийн төлөө үзэлцэж байлаа. Орос, Америк, Австрали, Герман, Англиас ирчээсэн тэр олон хүн тасалбар худалдагч нарыг тал талаас нь шаван сул суудал олж өгөөч гэж гуйж царайчлан өөр өөрийн хэлээр хашгиралдана. Нэгэн загзагар ирланд хүн олны дотроос тохойгоороо ёворч түлхэн гарч ирэхийг Жеми хараад,

-Уучлаарай, энд юу болж байна вэ? гэсэнд,

-Гойд юмгүй. Хөөтэй муу мухлаг тэргэний тасалбарыг бүтэн сар хагасаар урьдчилан худалдаж дууссан гэнэ гэж дургүйцэн бөвтөөд Жемийн цөхрөнгөө барсан царай харж,

-Энэ ч бас хамгийн аймшигтай нь биш ээ хо. Энэ мусайн турсаганууд нэг суудалд 500 фунт нэхэж байна гэлээ. Бүр хүн үнэмшмээргүй юм.

-Алмасын уурхайд хүрэх өөр ямар нэгэн арга байх ёстой доо.

-Нэг бол явган явах, эсвэл “Голланд шуудан”-аар явах, ийм л хоёр арга бий.

-“Голланд шуудан” гэдэг нь юу юм бэ?

-Ухэр тэрэг. Цагт хоёр миллийн хурдтай явдаг. Чамайг тэр газарт хүрэх гэсээр байтал хамаг алмасыг түүж аваад дуусна. Жеми хамаг алмасыг түүж аваад дуустал Кейптаунд саатахыг хүссэнгүй. Өглөөжин өөр ямар нэг тээвэр олох гэж хөөцөлдлөө. Тэгээд үдийн хэрд түүнд нэг аз таарчээ. Жеми “шуудан” гэсэн хаягтай адууны жүчээний дэргэдүүр явж байгаад дотогшоо шагайсанд ясан хэлхээ болсон нэг хүн том том шуудайтай шуудангийн ачаа тэрэг дээр ачиг байхыг харав. Жеми гэнэт сэтгэл шулуудан,

-Уучлаарай. Та Клипдрифтэд шуудан хүргэдэг үү? гэж асуулаа.

-Ай даа, одоо ачиг байгаа минь энэ гэхэд нь Жемийн сэтгэлд өчүүхэн горьдлого төрж,

-Хүн суулгах уу? гэсэнд тэр хүн Жемийг анхааралтай ажиг шинжээд,

-Заримдаа авч явдаг. Чи хэдэн настай вэ? гэлээ. Хачин асуулт байна.

-18 тай. Юу гэж?

-Бид нас 31-ээс хэтрээгүй залуу хүн авч явдаг. Чиний бие эрүүл чийрэг үү? Бүр хачин асуулт байна.

-Эрүүл чийрэг ээ, эрхэм ээ гэсэнд туранхай эр нуруугаа цэхэлж,

-Чи таарна. Би нэг цагийн дараа хөдөлнө. Чамаас 20 фунт авна даа гэхэд нь Жеми ийм аз таарсанд итгэж ядан,

-Яасан сайн юм бэ. Би яваад чөмөданаа аваад ирье... гэсэнд,

-Чөмөдон хэрэггүй. Нэг цамц, шүдний сойз аваад явбал болно гэжээ. Жеми шуудангийн тэргийг анхааралтай харвал тэр жижигхэн тэрэг дээр зузаан банз эв хавгүй хадаж эвлүүлэн хайрцаг хийж, дотор нь шуудантай уут хийжээ. Хайрцаг дээр дэлбэгчтэй нуруугаараа нийлүүлээд нэг хүн сууж багтах зай байлаа. Аян зам тун хүнд байх төлөвтэй.

-Яриа таарлаа. Би явж цамц, шүдний сойз аваад ирье гэж Жеми хэлэв. Жеми эргэж ирэхэд дэлбэгч морио тэргэнд хөллөж, хажууд нь хоёр өндөр залуу зогсож байгаагийн нэг нь хар арстан, нөгөө нь цайвар шар үстэй швед хүн аж. Тэр хоёр залуу дэлбэгчид мөнгө өгч байгаа харагдлаа.

-Байзаарай. Та намайг авч явна

гэсэн шүү дээ гэж Жеми өгүүлэхэд,

-Та гурав гурвуулаа явна. Гараад суулга гэж дэлбэгч хэллээ.

-Голланд шуудан”-аар явах, ийм л хоёр арга бий.

-Гурвуулаа юу?

-Гурвуулаа.

Энэ жижигхэн тэрэг дээр бүгдээрээ яаж багтахыг Жеми огт мэдэхгүй байсан боловч ямар ч гэсэн өөрөө заавал явна гэдгийг мэдэж байлаа.

Тэгээд хамт явах



хамгаална. Хэсэг явж байгаад зогсоход зорчигчид амарч, биеийн чилээгээ гаргах боломжтой. Аялал 10 хоног үргэлжилнэ. Харин шуудангийн тэрэг бол хааяа нэг морь, дэлбэгчээ солиод зогсолтгүй явна. Хээр талын гүн ховилтой замаар морьд цогцулна. Тэрэг нь нумгүй болохоор донслох бүрт бие доргино. Жеми шүд зуун “Би орой болтол тэсэх хэрэгтэй. Орой ууж идэж, унтаж амраад өглөө болоход хүч тэнхээ сэргэнэ” гэж бодож явав. Гэтэл шөнө морио солих гэж 10 минут зогсоод цааш давхижээ.

-Бид хэдийд зогсож өл залгах юм бэ? гэж Жеми асуухад,

-Ердөө зогсохгүй. Бид ярах ёстой. Бид шуудан хүргэж ява улс шүү, эрхэм ээ гэж шинэ дэлбэгч

налцаав. Өчүүхэн ч хөдлөх зай үлдсэнгүй. “Энэ тийм аймшигтай юм биш” хэмээн Жеми өөрийн сэтгэлийг засав.

-Тэсээрэй гэж дэлбэгч хашгираад шуудангийн тэрэг Кейптауны гудамжаар Клипдрифтийн алмасын уурхайг зорин давхив. Үхэр хөллөсөн мухлаг тэргээр явахад арай тохитой. Кейптаунаас алмасын уурхай руу зорчигчдын сууж явдаг мухлаг нь уужуухан том, бризентэн дээвэр нь төөнөн халуунаас

дургүйцэн бөвтнөжээ. Тэд сарны гэрэлд гийсэн тоос боссон энхэл донхол замаар шөнөжин давхилаа. Замын бартаа бүр дээр тэрэг донслоход Жемийн хамаг бие шархиран өвдөх болов. Үхтлээ ядарсан боловч унтаж чадахгүй байлаа. Жаахан зүүрмэлэж байтал тэрэг донслон сэрээнэ. Ядахдаа сунаах зай ч байхгүй учир хамаг бие нь хөшин чилжээ. Гэдэс нь өлсөж, үргэлж явсаар байгаад дотор нь муухайрч байлаа. Дараагийн удаа чухам хэдийд хоолтой зөлгөхыг мэдэхгүй байв. Клипдрифт хүргэлх 600 миль зай бий. Жеми Макгрегор амьд мэнд тэсэж хүрэх эсэхээ мэдэхгүй болжээ. Ер нь тэнд хүрэх хүсэл байгаа эсэхээ ч

хүнээс гадна тус бүр хорь шахам шар хөллөсөн мухлаг тэргэний цуваа ч үзэгдэнэ. Хөтөч нар нь урт нарийхан шилбүүрээр тас няс шавхуурдан “Хөөг, хөөг” хашгиралдана. Том том мухлаг тэргээр олон мянган фунт хүнсний зүйл, бараа таваар алт, алмасын эрэлчдэд зориулсан багаж хэрэгсэл, майхан шуухан, зуух, гурил, нүүрс, керосин, дон тэргүүтнийг зөөж яваа нь энэ ажээ. Бас кофе, тутарга, чихэр, дарс, гутал, амттан, хөнгөлөг тэргүүтэн ч бий. Энэ мухлаг тэргэнийг бол Клипдрифтийг ертөнцийн бусад хэсэгтэй холбодог сэжим юмсанж. Аянчид Шар мөрийн гатлах үзэс элчилгүй хээр талын уйдаж үхэм нэг хэвийн байдал дуусч, ногоон бут сөөг үзэгдэх болов. Эндэхийн газар улаавтар өнгөтэй агаад өвс ногоо нь аясын зөөлөн салхинд найган намирна. Зарим газар навчны оронд өргөстэй одой модод үзэгдэнэ. “Тэснэ шүү, тэснэ” гэж Жеми хайнгахан бодов. Тэгээд бага багаар горьдлого төрж эхэлхийг мэдэрлээ. Дөрвөн өдөр, дөрвөн шөнө аян замын аймшигт алжаалыг туулсны эцэст тэртээ хол Клипдрифтийн бараа торолзон үзэгдлээ. Өөрийг нь чухам ямар хувь тавилан тосон хүлээж байгааг залуу Жеми Макгрегор мэдсэнгүй. Аян замд ядарснаас улайсан нүдний нь өмнө гайхмаар хачин дүр зураг үзэгдэв. Клипдрифт гэдэг нь Вааль голыг хөөвөлсөн гол гудамжны дагуу босгон тавьсан өдий төдий майхан тэргэний орон байв. Балнар муухай замаар нүцэн бие дээрээ хурц өнгийн шиджак өмссөн африкууд, алт алмасын бавгар сахалтай эрэлчид, мах, тахны худалдаачин, багш, хулгайч байрын хүмүүс хөллөдөнө. Клипдрифтийн төвд дэлгүүр, гуанз, биллгярдын өрөө, өмгөөлөгчийн контор болдог модон байшин, алмас худалдан авдаг мухлаг эгнээжээ. Гудамжны буланд “Эзэн вангийн гулдан” нэртэй, хошорч ховхорсон хана нь нэг ч цонхгүй зочид буудал байх агаад өрөө тасалгаа нь цонхгүй ажээ. Жеми тэргэнээс буумагч хол нь биеэ даахаа больж, хөсөр унан тэрийж хэвтлээ. Тийнхүү босох тэнхэлтэй болтол тэр чигтээ хэвтэв. Толгой нь заадсаараа ангалзан өвдөнө. Жеми гудамж, явган замаар дүүрэн шуугин бужигналдах олны дундуур зочид буудал руу салгалан очив. Түүнд ханыг нь хар ялаа битүү шавсан бөгчим халуун өрөө таарчээ. Тэнд эрхбиш нэг ор байлаа. Жеми орон дээр бүхлээрээ унаж, агшин зуур унтаад өгчээ.

Үргэлжлэл дараагийн дугаарт

ТЭНГИС КИНО ТЕАТР

8 / 18 - 21

УЗВЭРИЙН ХУВААРЬ

<p>10:30 12:30 14:30 15:20 16:30 18:30 20:10</p>	<p>10:50 12:20 14:30 16:40 18:55 20:30 21:10 23:20</p> <p>Vip 13:45 22:25</p>	<p>10:45 12:30 17:25 20:25 22:45</p>	<p>15:10 22:15</p>

ШИНЭ
ТӨСӨӨЛЛӨВС ИЛҮҮГ ТЭНГИСЭЭС...